



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 50 (187)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Ерөнхийлөгчийн хоригийн тухай*
- *Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Гаалийн татварын хувь хэтжээг өөрчлөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот  
2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны арванхоёрдугаар сарын 30 №50 (187)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

536. Ерөнхийлөгчийн хоригийн тухай	Дугаар 54	865
537. Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай	Дугаар 55	865

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

538. Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай	Дугаар 171	866
539. Дүрэм батлах тухай	Дугаар 172	866
540. Эрх олгох тухай	Дугаар 173	868
541. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай	Дугаар 174	868
542. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 175	869
543. Дүрэм батлах тухай	Дугаар 176	871
544. Хуваарь батлах тухай	Дугаар 177	873
545. Журам батлах тухай	Дугаар 178	874

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорьдугаар зүйл, жаран есдүгээр зүйлийн 1, 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан

нэмэлт, өөрчлөлтөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Л. ЭНЭБИШ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

### Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төсвийн орлогын тодорхой эх үүсвэр бүрдүүлж, 2000 оны төсөвт төлөвлөгдсөн цалин, тэтгэвэр, тэтгэмжийн санхүүжилтийг санхүүгийн жилд нь багтаан олгох, орон нутагт үүссэн төсвийн

өрийг барагдуулах зорилгоор Засгийн газраас 8.0 /найм/ хүртэл тэрбум төгрөгийн бонд гаргахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Л. ЭНЭБИШ



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

### Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай

"Гаалийн тарифын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хилийн Цагааннуур, Даян, Асгатын гол, Бургастай, Арц суурь, Тэс, Давст, Боршоо, Байтаг, Ярант, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор 2000 оны 11 дүгээр сарын 1-нээс 2001 оны 4 дүгээр сарын 20 хүртэл хугацаанд импортоор орж

ирэх гурилын импортын гаалийн татварын хувь хэмжээг "О" байхаар өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН САЙД

Д.НАСАНЖАРГАЛ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

### Дүрэм батлах тухай

Иргэний бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Иргэний бүртгэл, мэдээллийн улсын

хяналтын дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Н.ЭНХБАЯР

Ц.НЯМДОРЖ

*Засгийн газрын 2000 оны  
172 дугаар тогтоолын хавсралт*

### ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмийн зорилго нь иргэний бүртгэл, мэдээлэлтэй холбогдсон хууль тогтоомж, түүнийг үндэслэн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, зааврын биелэлтийг хангуулахад оршино.

2. Иргэний бүртгэл, мэдээллийн төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, сум, дүүрэгт улсын ахлах байцаагч улсын байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх) иргэний бүртгэл, мэдээллийн улсын хяналтыг хэрэгжүүлнэ.

3. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

4. Улсын ерөнхий байцаагч аймаг, сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр дээд боловсролтой бөгөөд хуульч буюу эдийн засагч, эсхүл хүн ам зүйч мэргэжил эзэмшсэн иргэний бүртгэл, мэдээллийн ажилтанд улсын байцаагчийн эрх олгох асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд санал болгоно.

5. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, заавар болон энэ дүрмийг удирдлага болгоно.

6. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагч нь батлагдсан загвар

бүхий үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон акт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлага, ажиллах нөхцөл бололцоогоор хангах болон тэдний мэргэжлийг дээшлүүлэх, хийсэн хяналт шалгалтын дүнг үзэгтгэн, шаардлагатай бол холбогдох шийдвэр гаргахыг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв хариуцна.

Хоёр. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын хяналтын чиглэл

8. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а) иргэний бүртгэл, мэдээллийн талаархи хууль тогтоомж, Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

б) Монгол Улсын нэгдэн орсон иргэний бүртгэлийн талаархи олон улсын гэрээний биелэлтийг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн үйл ажиллагаанд шалгах.

Гурав. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

9. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагч дараахь үүрэг хүлээнэ:

а) иргэний бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаанд улсын хяналтыг хэрэгжүүлэхдээ Иргэний бүртгэлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авах, хяналтын үр дүнг мэдээлэх, сурталчлах;

б) зөрчил, дутагдлын шалтгааныг судалж тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэл, энэ талаар баримтлах бодлогын төслийг боловсруулж холбогдох газарт оруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

в) хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг судалж арилгах талаар холбогдох

байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд акт, мэдэгдэл бичих, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

г) бүртгэл үйлдэхэд шаардлагатай баримт бичгийн бүрдэл, тэдгээрийн үнэн зөвийг шалгах;

д) бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв үйлдэх, тайлан мэдээг нэгтгэн гаргах;

е) албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх.

10. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а) хяналт шалгалтын ажилд шаардлагатай баримт бичиг, мэдээ, судалгаа, тодорхойлолтыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулж авах;

б) холбогдох байгууллагын удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр хяналт шалгалтын ажилд зохих мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, шинжээчийг томилон ажиллуулах;

в) шаардлагатай гэж үзвэл шалгалтын материалыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

г) Иргэний бүртгэлийн тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, тухайн баримт бичигтэй холбоотой бусад баримт сэлтийг акт үйлдэн хураан авч, зохих журмын дагуу шийдвэрлэх.

11. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага, шийдвэрийг байгууллага аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлж хариу мэдэгдэх үүрэгтэй.

12. Иргэний бүртгэл, мэдээллийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг дээд шатны улсын байцаагч шийдвэрлэх бөгөөд түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргана.

Дөрөв. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын хяналтын дүрэм зөрчигчид хүлээлгэх хариуцлага

13. Улсын байцаагч нь хууль болон энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай, Иргэний бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

14. Иргэний бүртгэлийн журам зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай, Захиргааны хариуцлагын тухай болон Тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

### Эрх олгох тухай

Иргэний бүртгэлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга Аюурзанын Энхжавт Иргэний бүртгэл, мэдээллийн

хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрх олгоосугай.

**МОНГОЛ УЛСЫН**

**ЕРӨНХИЙ САЙД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД**

**ХЭРГИЙН САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

### Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

"Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 1997 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 205 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**

**ЕРӨНХИЙ САЙД**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ**

**САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**Ч.ГАНЗОРИГ**

*Засгийн газрын 2000 оны 174 дүгээр тогтоолын хавсралт*

## СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	- Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга
Дэд дарга	- Мөн төвийн дэд дарга
Гишүүд:	- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын албаны дарга - Дэд бүтцийн улсын хяналтын албаны дарга - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга - Санхүү, эдийн засгийн яамны Салбарын хөгжлийн удирдлага,

зохицуулалтын газрын мэргэжилтэн

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Эдийн засаг, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын орлогч дарга
- Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын дарга
- Үйлдвэр, худалдааны яамны Үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
- Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга
- Зэвсэгт хүчний ерөнхий штабын Хэмжил зүй, техник хяналтын албаны дарга
- Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч /тохиролцсоноор/
- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн /тохиролцсоноор/.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

### Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас баталсан "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт ТОГТООХ нь: Засгийн газрын 1995 оны 12 дугаар зүйлийн жагсаалт"-д дор дурдсан нэмэлт сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор оруулсугай:

130.

Дурсгалын нэр: ГОМБО ГҮР  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: 1587 он  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 18x10x 6см, лад чулуу  
 Дансны дугаар: 1/170, 65/1653

131.

Дурсгалын нэр: ДОРЖСЭМБЭ  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: XIX зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 22x14x11 см, гууль цутгамал, алт шармал  
 Дансны дугаар: 1/58

132.

Дурсгалын нэр: АЮУШ  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: ХҮШ зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 25x12x16 см, гууль цутгамал, алт шармал  
 Дансны дугаар: 1/8-Б"



133.

Дурсгалын нэр: **НОГООН ДАРЬ ЭХ**  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: ХҮШ зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 24,3x19,3x11см, гууль цутгамал, алт шармал  
 Дансны дугаар: 1/4, 65/501

134.

Дурсгалын нэр: **МАНЗУШИРИ**  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: ХҮШ зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 27,7x17x10 см, гууль цутгамал, алт шармал  
 Дансны дугаар: 1/1, 65/513

135.

Дурсгалын нэр: **МАНАЛ**  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: ХҮШ зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 30x21x12,5 см, гууль цутгамал, алт шармал  
 Дансны дугаар: 1/10, 65/589

136.

Дурсгалын нэр: **БУРХАН БАГШ**  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: ХҮШ зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 29,5x23x18 см, гууль цутгамал, алт шармал  
 Дансны дугаар: 1/7, 65/60

137.

Дурсгалын нэр: **СУВАРГА**  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: ХҮП зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 47x27x25 см, гууль цутгамал, алт шармал  
 Дансны дугаар: 1/34, 65/206

138.

Дурсгалын нэр: **ШАГШ ЖАНРАЙСИГ**  
 Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх урчууд  
 Хэдийд бүтээгдсэн: ХҮП зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 50x37x28 см, гууль цутгамал, алт шармал  
 Дансны дугаар: 2/6, 65/490

139.

Дурсгалын нэр: **ПУНЦАГТҮСЭМ**  
 Зохиогч: Агвааншаравын сургууль  
 Хэдийд бүтээгдсэн: ХҮШ зуун  
 Хадгалагдаж байгаа газар: Эрдэнэ зуу музей  
 Дурсгалын шинж байдал: 200x110см, Танка, даавуу, шороон будаг  
 Дансны дугаар: 4/107, 65/1522

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**
**Н.ЭНХБАЯР**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**
**А.ЦАНЖИД**





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

### Дүрэм батлах тухай

Засгийн газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын албаны дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 1998 оны

9 дүгээр сарын 9-ний өдрийн 172 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

**А.ЦАНЖИД**

*Засгийн газрын 2000 оны 176 дугаар тогтоолын хавсралт*

### БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ УЛСЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

тус томилж, чөлөөлнө.

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын албаны зорилт нь боловсрол, соёл, шинжлэх ухааны талаархи хууль тогтоомжийн хэрэгжилт, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандарт, түвшин, түүнтэй холбогдсон норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавьж биелэлтийг хангуулахад оршино.

2. Хяналтын албаны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд баталгаажуулна.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтыг улсын хэмжээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын алба /цаашид "хяналтын алба" гэнэ/, орон нутагт бүх шатны Засаг дарга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

4. Хяналтын албаны дарга нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

5. Хяналтын албанд ажиллах улсын байцаагч, улсын ахлах байцаагч /цаашид "байцаагч" гэнэ/-ыг улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, орон нутаг дахь хяналтын улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчтай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга тус

6. Байцаагч нь сургалт, эрдэм шинжилгээ, соёл, урлагийн талаар өндөр мэдлэгтэй, төрийн албанд зохих түвшинд бэлтгэгдсэн, хяналт шалгалтын ажлын дадлага, туршлагатай байвал зохино.

7. Хяналтын алба нь эрхэлсэн ажлын чиглэлээр улсын байцаагчдыг багийн зохион байгуулалтаар ажиллуулж болно.

8. Хяналтын алба нь зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Хяналтын албаны эрх, үүрэг

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын алба нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/холбогдох байгууллагын удирдлагатай тохиролцож мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, тест зохиох, мэргэжлийн дүгнэлт гаргуулах зорилгоор шинжээч гэрээгээр ажиллуулах;

б/шалгалтаар илэрсэн зөрчлийг хэрхэн барагдуулсан болон зохиосон ажлын талаар мэдээлэхийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс харну авах;

в/хууль тогтоомж зөрчин сургалтын байгууллага байгуулсан болон сургалт явуулсан бол үйл ажиллагааг нь түр буюу бүрмөсөн зогсоох асуудлыг боловсролын



асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх, шаардлагатай бол түр зогсоох шийдвэр гаргах;

г/хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох материалыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

д/улсын байцаагчийн тавьсан актыг батлах;

е/боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн талаархи хууль тогтоомжийг салбарын удирдах ажилтан, мэргэжилтэн, суралцагч болон бусад үйлчлүүлэгчид сурталчлах, дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлэх;

ё/шалгалтын мөрөөр авах арга хэмжээний талаар санал боловсруулж боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын алба нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

б/сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын стандартын биелэлтийг шалгаж, үнэлгээ өгөх;

в/сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын агуулгын стандартын хэрэгжилтийг үнэлэх, тестүүд боловсруулан тэдгээрийн санг бүрдүүлж, үйлчилгээ үзүүлэх;

г/боловсрол, соёл, шинжлэх ухааны төсөвт байгууллагын төсөв, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж зөрчлийг арилгуулах;

д/боловсрол, соёл, шинжлэх ухааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар нутгийн захиргааны байгууллагаас бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаад хяналт шалгалт хийж, үнэлгээ өгөх;

э/байцаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх, улсын байцаагчдыг арга зүйн удирдлагаар хангах.

Гурав. Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын албаны улсын байцаагчийн эрх, үүрэг

1. Улсын байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/хяналт шалгалт хийх явцад шаардлагатай тайлан, мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолтыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулж авах;

б/холбогдох байгууллагатай нь тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах;

в/бүх шатны сургууль, цэцэрлэг, байгууллага, аж ахуйн нэгжийн зүгээс хууль тогтоомж зөрчин сургалт явуулсан тохиолдолд сургалтыг зогсоох асуудлыг уг байгууллага буюу улсын ерөнхий байцаагчид тавьж шийдвэрлүүлэх;

г/хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд хугацаатай албан шаардлага өгч, биелэлтийн талаар хариу авах;

д/хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн сургууль, цэцэрлэг байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох асуудлыг ерөнхий байцаагчид тавьж шийдвэрлүүлэх.

2. Байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/байцаагч нь үйл ажиллагаандаа боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар гарсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар болон энэхүү дүрмийг удирдлага болгох;

б/байцаагч нь боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн талаархи хууль тогтоомж, боловсролын стандартын хэрэгжилтэд хяналт тавих;

в/түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж илэрсэн дутагдлыг арилгуулах;

д/хийсэн шалгалтын дүнг үндэслэн мэргэжлийн дүгнэлт гаргах.

Дөрөв. Бусад зүйл

1. Хяналтын албаны улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор мэдээлж байх үүрэгтэй.

2. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан нь улсын байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд гомдлоо Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын ерөнхий байцаагчид гаргана.

3. Улсын ерөнхий байцаагч нь гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргана.

4. Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

### Хуваарь батлах тухай

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулж Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Засгийн газрын хуралдаанд түр эзгүй байгаа гишүүний хариуцсан асуудлыг хэлэлцүүлэх гишүүдийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Түр эзгүй байгаа Засгийн газрын гишүүний асуудлыг хуваарьт заасан Засгийн газрын гишүүн хэлэлцүүлэх боломжгүй бол насаар хамгийн ахмад Засгийн газрын гишүүнд хариуцуулж байсугай.

3. Түр эзгүй байгаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний асуудлыг Ерөнхий сайд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Түр эзгүй байгаа Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний ажил үүргийг хавсран гүйцэтгэх тухай» Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2000 оны 177 дугаар тогтоолын хавсралт

### ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНД ТҮР ЭЗГҮЙ БАЙГАА ГИШҮҮНИЙ ХАРИУЦСАН АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ГИШҮҮДИЙН ХУВААРЬ

1	Монгол Улсын Гадаад хэргийн сайдын түр эзгүйд	Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд
2	Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайдын түр эзгүйд	Монгол Улсын Гадаад хэргийн сайд
3	Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын түр эзгүйд	Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайд
4	Монгол Улсын Байгаль орчны сайдын түр эзгүйд	Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
5	Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын түр эзгүйд	Монгол Улсын Байгаль орчны сайд
6	Монгол Улсын Дэд бүтцийн сайдын түр эзгүйд	Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайд
7	Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын түр эзгүйд	Монгол Улсын Эрүүл мэндийн сайд
8	Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайдын түр эзгүйд	Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн сайд
9	Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн сайдын түр эзгүйд	Монгол Улсын Дэд бүтцийн сайд
10	Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын түр эзгүйд	Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулж хуралдааны үйл ажиллагааг шуурхай болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам"-ыг 1 дүгээр хавсралт, Засгийн газрын хуралдаанд оролцох албан тушаалтны жагсаалтыг 2 дугаар хавсралт, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын материал, төлөвлөгөөг хүргүүлэх албан тушаалтны жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус

баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хуралдааны дэг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 160 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Н.ЭНХБАЯР**
**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**
**Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2000 оны 178  
дугаар тогтоолын 1 дүгээр  
хавсралт

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Засгийн газрын хуралдаан /цаашид "хуралдаан" гэнэ/-ыг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон энэхүү журмыг баримтална.

2. Ээлжит хуралдааныг долоо хоног бүрийн лхагва гаригийн 9.00 цагаас эхэлнэ.

3. Ээлжит бус хуралдааныг Ерөнхий сайдын товлосноор буюу Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санал болгосноор зарлан хуралдуулна.

4. Хуралдааныг нээлттэй буюу хаалттай явуулахыг Ерөнхий сайд шийдвэрлэнэ. Хаалттай хуралдаанаар Төрийн Нууцын жагсаалтад орсон болон Ерөнхий сайд хаалттай хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн асуудлыг хэлэлцэнэ. Хаалттай хуралдаанд зөвхөн Засгийн газрын гишүүд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, тухайн асуудлыг хариуцсан ажилтан оролцож, нууцын ажилтан тэмдэглэл хөтөлнө.

5. Шаардлагатай гэж үзвэл аймаг, нийслэлийн Засаг дарга болон агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага,

холбогдох бусад хүмүүсийг оролцуулан хуралдааныг өргөтгөсөн хэлбэрээр хийж болно.

6. Ээлжит бус (энэ тохиолдолд журмын 34 дүгээр зүйл хамаарахгүй) болон өргөтгөсөн хуралдааныг хийхдээ энэхүү журмыг баримтална.

7. Хуралдааныг Засгийн газрын гишүүдийн гуравны хоёр нь оролцоноор хүчинтэйд тооцох бөгөөд хуралдаанд Засгийн газрын гишүүд таслах /батлах/ эрхтэй оролцоно.

8. Хуралдаанаар Засгийн газрын тухай хууль болон бусад хуульд заасан Засгийн газрын бүрэн эрхтэй холбогдсон асуудал, Улсын Их Хурлаас даалгасан, Ерөнхийлөгчөөс санал болгосон асуудал хэлэлцэх бөгөөд түүний дотор дор дурдсан асуудлыг заавал хэлэлцэнэ:

а/ хуулийн төсөл;

б/ хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бусад шийдвэрийн төсөл;

в/ Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийн төсөл;

г/ Засгийн газрын бодлогод

өөрчлөлт оруулахаар Засгийн газрын гишүүнээс ирүүлсэн санал /төсөл/;

д/Ерөнхий сайд дангаар шийдвэрлээгүй болон Засгийн газрын гишүүдээс эрхлэх асуудлаараа өөрсдөө тохиролцож чадаагүй саналын зөрөөг шийдвэрлэх асуудал.

9. Яамны Төрийн нарийн бичгийн дарга тухайн сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг өмнөх сарын сүүлчийн долоо хоногт багтаан Хэрэг эрхлэх газарт ирүүлэх бөгөөд түүний биелэлтэд Хэрэг эрхлэх газар хяналт тавина.

10. Хуулиар хамгаалсан нууцад хамаарахаас бусад асуудлаар гарсан Засгийн газрын шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

11. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм, гишүүдийн оролцсон байдал, энэхүү журмын хэрэгжилтийн судалгааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (цаашид "Хэрэг эрхлэх газар" гэнэ) улирал тутам нэгтгэж хуралдаанд танилцуулна.

Хоёр. Хуралдаанд хэлэлцүүлэх асуудалд санал авах, Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх

12. Хуралдаанд эрхлэх хүрээнийхээ асуудлыг Засгийн газрын гишүүн өөрөө хариуцан оруулна. Хэрэв уг асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн эзгүй байвал түүний хариуцсан асуудлыг Засгийн газраас баталсан хуваарийн дагуу хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүн оруулна.

13. Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг санаачилсан Засгийн газрын гишүүн буюу аймаг, нийслэлийн Засаг дарга уг төсөлд холбогдох яамны виз (санал)-ийг авна. Яам нь төслийг хүлээн авсан өдрөөс жойш ажлын 5 өдөрт багтаан виз (санал) өгөх бөгөөд хэрэв явуулснаас хойш 10 хоногт багтаан төсөлд виз (санал) ирүүлээгүй бол зарчмын өөр саналгүйд тооцно. Асуудлыг санаачлагч нь виз /санал/ өгөх хугацааг

заасан тохиолдолд түүнийг баримтална.

14. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэр нь тодорхой яамны салбарын бодлогын хүрээнд хамааралгүй бол Санхүү, эдийн засгийн болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бусад яамны саналыг авахгүй байж болно.

15. Асуудлыг санаачилсан Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга шаардлагатай гэж үзвэл Ерөнхий сайдаас санал авна.

16. Нэмэгдэл хөрөнгө шаардагдах асуудалд Санхүү, эдийн засгийн яамны виз (санал)-ийг заавал авсан байх бөгөөд ямар эх үүсвэрээс гаргахыг төсөлд тодорхой тусгана.

17. Засгийн газрын санаачлах хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд эцэслэн хянаж хуралдаанд оруулна.

18. Хуулийн төсөлд уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гарах шийдвэрийн төсөл, хэрэв хууль, Засгийн газрын тогтоолоор яам, агентлаг дүрэм, заавар гаргахыг даалгахаар бол тэдгээрийн төслийг хавсаргасан байна. Яам, агентлагаас батлах дүрэм, зааврын төсөлд Засгийн газрын гишүүн виз (санал) өгөхгүй боловч хууль, Засгийн газрын шийдвэрийн төсөлд санал өгөхдөө тэдгээрийг харьцуулж үзнэ.

19. Хуралдаанаар хэлэлцүүлэхээр боловсруулсан асуудлаар холбогдох төрийн бус байгууллагын санал авах буюу хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулж болно.

20. Холбогдох сайдаас ирүүлсэн саналыг төсөлд тусган боловсруулж Хэрэг эрхлэх газарт оруулах бөгөөд хэрэв саналыг хүлээн авах боломжгүй гэж үзсэн бол энэ тухай үндэслэлээ хүснэгтээр гаргаж танилцуулгад хавсаргана.

21. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачлан боловсруулж Засгийн газраас санал авахаар ирүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд өгөх

Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд бэлтгэж хуралдаанд хэлэлцүүлнэ.

22. Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохих тооцоо, судалгаанд тулгуурлан үндэслэл сайтай боловсруулж холбогдох материалын хамт тухайн асуудлыг хэлэлцэхээс 7-оос доошгүй өдрийн өмнө сайдын (түүний эзгүйд дэд сайдын) гарын үсэгтэй албан бичгээр Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.

23. Хуралдаанд танилцуулах мэдээлэл, сонсгол /Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндсэн чиглэл, төсөв, гэрээ, хэлэлцээрээс бусад/ 35 мөрөөр бичсэн 8 хуудаснаас, танилцуулга 4 хуудаснаас илүүгүй байна.

24. Хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газарт ирүүлсэн материалыг яамнаас хүлээж авахдаа Хэрэг эрхлэх газар дор дурдсан бүрдүүлэлтийг шалгаж үзнэ:

а/ материал нь хувилж олшруулах, архивын нэгж болгон хадгалах шаардлагын дагуу бэлтгэгдсэн эсэх;

б/ Хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд Хууль зүй, дотоод хэргийн яамны санал авсан эсэх;

в/ төсөв, хөрөнгийн холбогдолтой асуудалд Санхүү, эдийн засгийн яамны санал авсан эсэх;

г/ бусад нийтлэг асуудалд Санхүү, эдийн засгийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох яамдын саналыг авсан байдал.

25. Хэрэг эрхлэх газар нь яамнаас ирүүлсэн асуудлын үндэслэл тооцоо, судалгаа, уг шийдвэрийн төсөл нь тухайн асуудлаар урьд гарсан шийдвэр болон хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг үзнэ. Хэрэв боловсруулалт нь шаардлага хангаагүй буюу хууль тогтоомж, Засгийн газрын бусад шийдвэртэй нийцээгүй, эсхүл зөрчилдсөн буюу давхардсан гэж үзвэл тодорхой үндэслэл, тайлбарыг гарган

материалыг буцаах тухай асуудлыг хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

Гурав. Хуралдааны бэлтгэл хангах

26. Хуралдаанд хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг Хэрэг эрхлэх газарт хянан үзээд зохих хууль тогтоомж, бодлогод нийцүүлэх, найруулгын засвар хийх зэрэг өөрчлөлт оруулах шаардлагатай бол энэ тухай уг асуудлыг оруулсан Засгийн газрын гишүүнд танилцуулна.

27. Хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудал нь хууль тогтоомж, түүнчлэн Засгийн газрын бодлоготой нийцэхгүй гэж үзвэл Хэрэг эрхлэх газар саналаа боловсруулан хэлэлцүүлж болно. Энэ тохиолдолд үндэслэлээ тодорхой бичсэн танилцуулга хавсаргах бөгөөд төслийн эхэнд "Хэрэг эрхлэх газрын санал" гэж бичнэ.

28. Хуралдааны шийдвэрийн томъёоллыг тухайн асуудал оруулж байгаа Хэрэг эрхлэх газрын ажилтан хийж, хууль зүйн техникийн хувьд Хуулийн хэлтсээр хянуулна.

29. Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга хуралданд оруулах асуудлын төлөвлөгөө болон материалыг хянан үзээд Хэрэг эрхлэх газрын даргатай эцэслэн тохирсны дараа Ерөнхий сайдад танилцуулж хэлэлцэх асуудлын дарааллыг тогтооно.

30. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гаргахдаа олон хүн оролцох шаардлагатай буюу боловсон хүчин, улсын төсөв, Үндсэн чиглэл зэрэг асуудлыг эхний ээлжинд оруулж, Засгийн газрын нэг гишүүний эрхлэх ажлын хүрээний асуудлыг хэлэлцэж дуусгаад дараагийн гишүүний эрхлэх ажлын хүрээний асуудлыг хэлэлцүүлэх зарчмыг баримтална.

31. Хэрэг эрхлэх газар нь хуралдаанд оруулах материалыг олшруулан битүүмжилж Засгийн газрын гишүүд болон бусад холбогдох албан тушаалтанд хүргэх бөгөөд сайд буюу албан тушаалтанд өөрт нь эсхүл



туслахад нь хүлээлгэн өгч цагаа бичүүлэн гарын үсэг зуруулна.

32. Хуралдаанд оруулах асуудлын материал нь 15 хуудаснаас дээш бол түүнийг сүлжээгээр буюу дискээр хүргүүлнэ.

33. Нууц материалыг олшруулах ажлыг Хэрэг эрхлэх газрын нууц хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.

34. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, материалыг уг асуудлыг хэлэлцэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө Засгийн газрын гишүүдэд хүргэсэн байна.

35. Хуралдаанаар асуудал хэлэлцүүлэхэд оролцох ажилтан нь яамны газар, хэлтсийн дарга буюу түүнээс дээш албан тушаалтай байна. Шаардлагатай гэж үзвэл яамны холбогдох ажилтанг асуудал хэлэлцүүлэхэд оролцуулж болно. Хуралдаанд оролцох ажилтны албан тушаал, нэрийг Хэрэг эрхлэх газрын тухайн асуудлыг хариуцсан ажилтан урьдчилан гаргана.

36. Хэлэлцэж байгаа асуудлын талаар зохих байгууллага нэгэнт зөвшөөрсөн санал албан ёсоор өгсөн байвал холбогдох хүмүүсийг хуралдаанд оролцуулахгүй байж болно.

37. Хуралдаанд гаднаас орох хүмүүсийн нэрсийн жагсаалтыг Хэрэг эрхлэх газар хуралдааны урьд өдөр нь Төрийн ордны хамгаалалтын албаны ээлжийн ахлагч болон хуралдааны танхимд нэвтрэх хаалганы хамгаалалтын ажилтанд тус бүр нэг хувийг өгнө.

38. Хуралдааны зохион байгуулалт, байрны нөхцөл, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах ажлыг Хэрэг эрхлэх газар хариуцна.

Дөрөв. Хуралдаан хийх

39. Хуралдааныг Монгол Улсын Ерөнхий сайд даргална. Ерөнхий сайдын эзгүйд хуралдааныг түүний үүргийг түр гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн

даргална.

40. Засгийн газрын гишүүний эзгүйд дэд сайд хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцоно.

41. Хуралдаанд асуудал хэлэлцэхэд оролцох хүмүүсийг Хэрэг эрхлэх газар нэрсийн жагсаалтын дагуу хуралдааны танхимд оруулна.

42. Хуралдаанд дор дурдсан дотоод журмыг баримтална:

а/ хуралдаан даргалагч хуралдааныг нээж тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг Засгийн газрын гишүүд зөвшөөрч байгаа эсэхийг лавласны үндсэн дээр хэлэлцэх асуудлыг тодотгож, төлөвлөгөөнд орсон дарааллын дагуу нэг асуудлыг хэлэлцэж дуусаад дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ;

б/ төлөвлөгөөнд ороогүй боловч хуралдаанаар зайлшгүй нэн яаралтай хэлэлцэж шийдвэрлэх шаардлагатай асуудал гарвал хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмэн оруулж болно;

в/ хэлэлцэх асуудлын танилцуулгыг тухайн асуудлыг оруулж байгаа Засгийн газрын гишүүн, түүний эзгүйд Засгийн газраас баталсан хуваарийн дагуу хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүн хийнэ;

г/ аймаг, нийслэлийн Засаг дарга санаачилсан асуудлаа өөрөө оруулж хэлэлцүүлнэ;

д/ хэлэлцэж байгаа асуудалд холбогдох зураг, видео бичлэг, биет зүйлс, түүний загвар, хэсгийг хуралдаан дээр үзүүлж болно;

е/ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариултыг дуусгасны дараа хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр санал гаргах боловч нэг асуудлын талаар гурваас илүүгүй удаа санал гаргана. Нэг удаа санал гаргах, үг хэлэх хугацаа тухай бүр 5 минутаас хэтрэхгүй байна. Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэж байгаа асуудлаар Хэрэг эрхлэх газрын



тэргүүн дэд, дэд дарга болон холбогдох ажилтан тайлбар өгч болно;

ж/ асуултыг Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр хуралдаанд оролцож буй бусад хүмүүс тавих бөгөөд асуулт, хариулт, санал нь хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой, товч тодорхой байна;

з/ Засгийн газрын гишүүн Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, хуралдааны журмыг чанд сахин, хэлэлцэж байгаа асуудалд анхааралтай хандаж, асууж лавлах, санал гаргаж үг хэлэхдээ хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авна;

и/ хуралдаанд асуудал оруулж байгаа хүмүүс асуултанд хариулахдаа эхлээд босч өөрийгөө танилцуулах бөгөөд хэрэв тайлбар хийх, үг хэлэх шаардлагатай бол хуралдаан даргалагчид хандаж зөвшөөрөл авна;

л/ хуралдаан даргалагч тухайн асуудлыг хэлэлцэж дууссаныг болон хуралдаан дууссаныг алх цохин мэдэгдэнэ;

м/ хуралдааны үед гар утсаар ярих, хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр 5 минутаас дээш хугацаагаар түр гарахыг хориглоно;

н/ Засгийн газрын гишүүн чөлөө авч хуралдаанаас гарсан нөхцөлд үлдэж хуралдах гишүүдийн тоо нийт гишүүний гуравны хоёрт хүрэхгүй бол хуралдаан завсарлана;

о/ Засгийн газрын нээлттэй хуралдааны ажиллагааг сурвалжлах хүмүүсийг хуралдааны танхимд оруулах зөвшөөрлийг Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга олгоно.

43. Хуралдаанаар хэлэлцэх асуудалд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчөөс бичгээр ирүүлсэн саналыг хуралдаан даргалагч танилцуулан хэлэлцүүлэх бөгөөд шийдвэрт хэрхэн тусгагдсан талаар үг асуудлыг хэлэлцсэнээс хойш ажлын 7 өдөрт багтаан Хэрэг эрхлэх газар хариу мэдэгдэнэ.

44. Хуралдааныг 2 цаг тутамд завсарлагатай хийх бөгөөд завсарлагын

хугацааг хуралдаан даргалагч тухай бүр тогтооно.

45. Хамгаалалтын ажилтан хуралдааны танхимд орох хүмүүсийн түр нэвтрэх зөвшөөрлийн бичгийг нэрсийн жагсаалттай тулган шалгаж оруулна.

Тав. Шийдвэр гаргах

46. Хуралдаан даргалагч хэлэлцэж байгаа асуудлын талаар гарсан саналыг нэгтгэн дүгнэж шийдвэрийн төслийг уншиж сонсоно.

47. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг шийдвэр гарган батлах, шийдвэр гаргах шаардлагагүй гэж буцаах, хугацаа тогтоон дахин боловсруулахаар хойшлуулах гэсэн гурван хэлбэрээр шийдвэрлэнэ.

48. Хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын талаар Засгийн газрын тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана.

49. Хуралдаанаар хэлэлцэн баталсан шийдвэрт хуралдаанаас хойш зарчмын өөрчлөлт хийхийг хориглоно. Зарчмын өөрчлөлт хийх шаардлага гарвал хуралдаанаар дахин хэлэлцүүлнэ.

50. Хуралдааны шийдвэрийн эцсийн томъёоллыг Хэрэг эрхлэх газрын болон холбогдох яамны ажилтнууд хийж, Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга хянаж гарын үсэг зурна.

51. Хуралдаанд оролцож эмжаагүй Засгийн газрын гишүүдэд хуралдааны шийдвэрийг Хэрэг эрхлэх газар нөхөн танилцуулж байна.

Зургаа. Хуралдааны явцыг баримтжуулах, хуралдааны шийдвэрийг нийтлэх, сурталчлах

52. Хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын талаар гарах тогтоол, захирамжийн төслийг Хэрэг эрхлэх

газрын даргаар нотлуулахын өмнө тухайн асуудлыг хариуцсан Хэрэг эрхлэх газрын ажилтан Хуулийн хэлтсээр хянуулна.

53. Хуралдаанаас гарах Засгийн газрын тогтоолыг Хэрэг эрхлэх газар ажлын 3 хоногт багтаан эхлээд түүний биелэлтийг хариуцсан сайдаар, дараа нь Ерөнхий сайдаар гарын үсэг зуруулна.

54. Ерөнхий сайдын эзгүйд түүний үүргийг түр гүйцэтгэж тухайн хуралдааныг даргалсан Засгийн газрын гишүүн тогтоолд Ерөнхий сайдыг төлөөлөн гарын үсэг зурна.

55. Хуралдаанаар хэлэлцэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон асуудлыг тухайн асуудал хариуцсан Хэрэг эрхлэх газрын ажилтан ажлын 7 өдөрт багтаан бэлэн болгож, Хэрэг эрхлэх газрын даргад танилцуулан Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлнэ.

56. Хэрэг эрхлэх газар Засгийн газрын тогтоолыг гарын үсэг зурагдсанаас хойш ажлын нэг өдөрт багтаан Төрийн ордон дахь байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ. Яам, агентлаг, бусад байгууллагад мөн өдөртөө багтаан хүргүүлэхээр Төрийн тусгай холбооны газрын Төрийн ордон дахь салбарт шилжүүлнэ.

57. Хуралдааны явц, хуралдаан дээр хүмүүсийн хэлсэн үг, гаргасан саналыг Хэрэг эрхлэх газар соронзон хальсанд бичиж цаасан дээр буулгана. Шаардлагатай гэж үзвэл Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргын зөвшөөрснөөр хуралдааны явцын талаар дүрс бичлэг хийж болно.

58. Хаалттай хуралдааны тэмдэглэлийг Хэрэг эрхлэх газрын нууц хариуцсан ажилтан соронзон бичлэг хийж цаасан дээр буулгана.

59. Хуралдааны явцын талаар хураангуй тэмдэглэлийг давхар хөтөлнө. Хураангуй тэмдэглэлд хэлэлцсэн асуудлын нэр, түүнийг танилцуулсан хүний албан тушаал, нэр, үг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай тусгана. Хураангуй тэмдэглэлийг Хэрэг эрхлэх газар ажлын 2 өдөрт багтаан албажуулна.

60. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг ажлын 7 өдрийн дотор бэлэн болгоно.

61. Хуралдааны явцын хураангуй болон дэлгэрэнгүй тэмдэглэлийг Хэрэг эрхлэх газрын Зохион байгуулалтын хэлтсийн дарга эцэслэн хянасны дараа тэргүүн дэд дарга гарын үсэг зурна. Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргын эзгүйд түүний нэрийн өмнөөс тус газрын дэд дарга гарын үсэг зурна.

62. Хуралдааны тэмдэглэлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

а/ тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт;

б/ Засгийн газрын гишүүдийн ирцийн байдал /тоо, хувь, хурлаас хоцорсон болон хуралд оролцоогүй гишүүний нэр, шалтгаан/ болон хуралдаанд оролцсон бусад хүний албан тушаал, нэрс.

63. Хуралдааны хураангуй тэмдэглэлийн шаардлагатай хэсгийг Хэрэг эрхлэх газар холбогдох яам, агентлаг болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хуралдаан болсноос хойш ажлын 3 өдөрт багтаан шуудангаар илгээнэ.

64. Хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг Ерөнхий сайдын хэвлэл мэдээлэл хариуцсан алба зохион байгуулна. Харин хуралдаан болохоос өмнө хэлэлцэх асуудал, шийдвэрийн төслийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.

65. Шаардлагатай гэж үзвэл Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга хуралдааны дараа хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлэл хийнэ.

66. Засгийн газрын хаалттай хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу нийтэд мэдээлж болно.

Засгийн газрын 2000 оны 178  
дугаар тогтоолын 2 дугаар  
хэвсрэлт

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНД ОРОЛЦОХ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

Нэг. Дор дурдсан албан тушаалтан хуралдаанд заавал оролцоно:

1. Төрийн хянан шалгах хорооны дарга.
2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга.
3. Ерөнхий сайдын ажлын хэсгийн ахлагч
4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Зохион байгуулалтын хэлтсийн дарга
5. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хуулийн хэлтсийн дарга.
6. Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга, ажилтан.

Хоёр. Дор дурдсан албан тушаалтан шаардлагатай гэж үзсэн асуудлаа хэлэлцэх үед оролцоно:

1. Монгол банкны ерөнхийлөгч.
2. Төрийн захиргааны албаны зөвлөлийн дарга.
3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч.
4. Ерөнхийлөгчийн зөвлөх.
5. Ерөнхий сайдын зөвлөх.
6. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга.

Засгийн газрын 2000 оны 178  
дугаар тогтоолын 3 дугаар  
хэвсрэлт

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН МАТЕРИАЛ, ТӨЛӨВЛӨГӨӨ ХҮРГҮҮЛЭХ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

Нэг. Материал, төлөвлөгөөг бүрнээр хүргүүлэх:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч.
2. Улсын Их Хурлын дарга.
3. Монгол Улсын Ерөнхий сайд.
4. Монгол Улсын Засгийн газрын гишүүд-12.
5. Төрийн хянан шалгах хорооны дарга.
6. Төрийн захиргааны албан зөвлөлийн дарга.
7. Монгол банкны ерөнхийлөгч.
8. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч.
9. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга.
10. Ерөнхий сайдын ажлын хэсгийн ахлагч.
11. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хуулийн хэлтсийн дарга
12. Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга.

Хоёр. Төлөвлөгөө хүргүүлэх:

1. Улсын Их Хурлын олонхийн бүлгийн ахлагч.
2. Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргах.  
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хяналт хэсэгт хэвлэн.

☎ 329487